

**ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА
БА АЛС ДОРНОДОД
ЭНХ ТАЙВАН, АЮУЛГҮЙ
БАЙДЛЫГ ХАНГАХ
ТУЛГАМДСАН АСУУДАЛ**

(Олон улсын эрдэм хурал Москва 1986)

Москва хотноо өнгөрөгч 1986 оны 11-р сарын 18—20-ны өдрүүдэд «Алс Дорнодод энх тайван, аюулгүй байдлыг хангах тулгамдсан асуудал» сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний бага хурал боллоо. ЗХУ-ын ШУА-ийн Алс Дорнотын Институтээс зохион байгуулсан нийгмийн ухааны салбарын эрдэмтдийн энэхүү томоохон уулзалтад БНБАУ, БНСВУ, БНАГУ, БНКУ, БНМАУ, БНУАУ, ЗХУ, БНСЧСУ-ын олон улс судлалын байгууллагуудын эрдэмтэд, зарим ах дүү намын төлөөлөгчид мөн Зөвлөлтийн ШУА-ийн Дорнодахины Институт, Дэлхийн эдийн засаг, Олон Улсын Харилцааны Институт, Дэлхийн Социалист системийн Эдийн Засгийн Институт, АНУ, Канадын Судлалын Институт, ЗХУ-ын Батлан хамгаалах Яамны Цэргийн Түүхийн Институт, Зөвлөлтийн ГЯЯ-ны Олон Улсын Харилцааны Институт, Зөвлөлтийн Алс Дорнотын болон бусад эрдэм шинжилгээний төвөөс уригдан ирсэн эрдэмтэн мэргэд оролцож чууллаа.

Эрдэм шинжилгээний бага хурал дээр өгүүлсэн үндсэн сэдэв буюу өөрийн хэлэлцэх хэргийг 5 зангилаа асуудал болгон тасалж хуралд томилогдсон илтгэлүүдийг агуулгаар нь тэрхүү 5 хэсэгт хувиарлан сонсож хэлэлцэх замаар ажлаа явуулав. Үүнд гол сэдвүүд:

- Ази, Номхон далайн бүс нутгийн олон улс дундын ерөнхий асуудлууд;
- Хятадын гадаад бодлогын асуудлууд;
- Японы гадаад бодлогын асуудлууд;
- Солонгосын хойг дахь байдал, тулгамдсан асуудлууд;
- Зүүн Өмнөд Азийн байдал, тулгамдсан асуудлууд-эдгээр болно.

Гол ба үндсэн илтгэлүүдэд социалист хамтын нөхөрлөлийн орнуудаас Ази, Номхон далайн бүс нутгийн энх тайван, аюулгүйн тусын тулд явуулж буй олон талт шинэ сэтгэлгээ бүхий гадаад бодлогын асуудлуудыг өнөөгийн дэлхий дахины байдлын хүрээ, диалектик холбоо уялдаа, эерэг болон сөрөг хүчин зүйл хөгжил өөрчлөлт дунд өргөн материал хэрэглэгдэхүүнд тулгуурласан үндсэн дээр эрдэм шинжилгээний иж бүрэн байр сууринаас авч үзсэн явдал судалгаа, ялангуяа улс төрийн нэн чухал ач холбогдолтой болсныг өргөн шүүмжлэлд оролцогч эрдэмтэд тэмдэглэв. Эрдэм шинжилгээний бага хурал ийнхүү өгүүлэн бүхий бүс нутгийн олон улсын харилцааны ерөнхий асуудлуудыг нарийвчлан авч үзээд ЗХУ, социалист хамтын нөхөрлөлийн орнууд болон бусад социалист, мөн социалист бус орнуудын санал санаачилгын харилцан цогцолдоо, бие биенийг нөхөн сэлбэх боломжийг алдалгүй, харин уртал болгох ухаалаг зарчмын үндсэн дээр Ази дахины энх ёс, аюулгүйн иж бүрэн систем тогтоож болох ба тогтоох ёстой, өөр зам үгүй гэсэн эрдэм шинжилгээний үндсэн дүгнэлт хийлээ. Чухам үүнд бүхий л хүн төрөлхтөнд

хамаарах гол гогцоо асуудлыг гүн гүнзгий, өргөн цараалаг байдлаар авч ярилцсан Москвагийн олон улсын эрдэм шинжилгээний бага хурлын ач холбогдол оршиж байна.

Бид сэтгүүлийнхээ энэ дугаарт тус бага хуралд ЗХУ-ын ШУА-ийн Алс Дорнотын институтын захирал, доктор М. Л. Титаренкогийн тавьж хэлэлцүүлсэн гол илтгэлийг товчилон орчуулж нийтэллээ.

**ЭНХ ТАЙВНЫ ТАЛААРХ
ЗӨВЛӨЛТИЙН СТРАТЕГИ БА
АЗИ-НОМХОН ДАЛАЙН БҮС НУТАГ**

М. Л. ТИТАРЕНКО
ЗСБНХУ-ын ШУА-ийн Алс Дорнотын
Институтын захирал, философийн шинжлэх
ухааны доктор

Олон улсын байдлыг эрүүлжүүлэх чиглэлээр ЗХУКН ба Зөвлөлт улсаас дэлхий дахины хэмжээнд тууштай явуулж байгаа олон талт, цөхрөлтгүй үйл ажиллагаанд Ази-Номхон далайн чиглэл онцгой байр эзэлдэг юм. Дэлхий дахины бодлогын хүрээнд Ази-Номхон далайн чиглэлийн улам нэмэгдэж байгаа ач холбогдол, Азийн янз бүрийн районд бие биеийн эсрэг зогсож байгаа цэрэг зэвсгийн хурцадмал байдлыг арилгаж, ерөнхий төлөв байдлыг нь тогтворжуулах зорилгоор цаг үеийн шаардлагатай эмзэг асуудлуудыг улс төрийн аргаар зохицуулах эрх ашгийн үүднээс хүчин чармайлтаа идэвхжүүлэхийн чухалыг ЗХУКН-ын XXVII их хурал онцлон заасан билээ.

Ази-Номхон далайн бүс нутгийг энх тайван, сайн хөршийн бүс болгох арга замыг сүвэгчлэхэд хүчирхэг түлхэц үзүүлэн улс түмний энх тайван хамтын ажиллагааны найдвартай үндэс суурь болохуйц Ази Номхон далайн бүс нутгийн олон улсын аюулгүй байдлын бат бэх систем тогтоох өргөн цар хүртгээтэй цогцолбор программыг М.С. Горбачев Владивостокт хэлсэн үгэндээ дэвшүүлэн тавьж энэ талаарх их хурлын заалтыг цаашид гүнзгийрүүлэн тодрууллаа.

Ази, Номхон далайн районы байдлыг эрүүлжүүлэх үйл явцад тус дөхөм үзүүлэх жинтэй хүчин зүйл бол уг районд орших улсууд ба ЭЗХТЗ-ийн гишүүн Европын социалист орнууд болон Кубын хамтын ажиллагааг өргөтгөх явдал болно. Дэлхийн янз бүрийн районд харилцан итгэлцэл ба аюулгүй байдлыг бататгахын төлөө цөмийн дайн, сансрыг зэвсэглэх явдлыг таслан зогсооход чиглэгдсэн ЗХУ-ын энх тайванч чармайлтыг социалист хамтын нөхөрлөлийн орнууд тууштай дэмжиж байна. Ийм зарчимч хандлагыг 1986 оны 6-р сард Будапештэд болсон Варшавын гэрээнд оролцогч улсуудын улс төрийн зөвлөлдөх хорооны ээлжит зөвлөлгөөн, 1986 оны 9— 10-р сард БНМАУ, БНАСАУ, БНХАУ-д хийсэн БНПАУ, БНАГУ-ын нам төрийн удирдагчдын нөхөрсөг айлчлалтын явц нотлон харууллаа.

I

ЗХУКН, Зөвлөлт улсын гадаад улс төрийн үйл ажиллагааны бүрэл дэхүүн хэсэг болох Ази-Номхон далайн чиглэл бол энэхүү бүс нутгийн бүх улс түмний аюулгүй байдлын дэлхий дахины ба бүсийн холбогдолтой асуудал, улс тус бүрийн ба нийтийн эрх ашгийг хамарсан өргөн цар хүрээтэй асуудал юм.

ЗХУ-ын нутаг дэвсгэрийн дөрөвний гурван хувь нь Ази тивд орших бөгөөд байгалийн асар их нөөц баялаг агуулагдсан энэ нутагт бүх холбоотын хэмжээний нийгэм-эдийн засгийн нөр их ажил ихээхэн далайцтай өрнөж байгаа билээ. М. С. Горбачевын хэлсэнчлэн «аль эртний байнгын оршин суугч, далайчид нь байсаар ирсэн бүхий л Алс Дорнод, Ази болон түүнд хамаарагдах тэнгисийн уудам нь бидний хувьд үндэсний хийгээд улсын эрх ашигтай нягт холбогдоно».

Дэлхий дахины улам өсөн нэмэгдэж байгаа харилцан хамааралыг харгалзан бүх Ази-Номхон далайн бүс нутаг, түүний олон сая ард түмний язгуур эрх ашгийг хүндэтгэх үүднээс манай улс ханддаг юм. Харин энэ район бол дэлхийн хамгийн их үймээнтэй район болоод байна. Олон улсын түгшүүртэй байдлын голомт, орон нутгийн мөргөлдөөнүүдийн дийлэнх олонхи нь чухам энд л байгаа юм. Хиросима, Нагасаки хотуудыг үнэс, чандруу болгосон цөмийн зэвсгийг Америкийн империализм чухам энд анх хэрэглэсэн бөгөөд дэлхийн хоёрдугаар дайнаас хойших хугацаанд хоёр хамгийн их цус урсгасан түрэмгийллийг Солонгос, Вьетнамд үйлдсэн билээ. Ази тивд АНУ зөвхөн сүүлийн жилүүдэд 230 шахам удаа зэвсэг хэрэглэсний дотор 33 тохиолдолд нь цөмийн зэвсэг хэрэглэх шахсан юм. «Шинэ глобализм»-ын чиг шугамаа баримталж Ази-Номхон далайн бүс нутгийн байдлыг тогтворгүй болгож хурцатгах, түүнийг ЗХУ, социалист бусад орнууд болон үндэсний чөлөөлөх хүч нүүдтэй сэргөлдөх цэрэг-улс төрийн сэргөлдөөний талбар болгон хувиргах оролдлогоо өнөөдөр АНУ-ын удирдах бүлэг идэвхжүүлсээр байна.

Ази-Номхон далайн бүс нутгийг цэрэгжүүлэлтийн байдал хэмжээний хувьд өнөө хирдээ Европт хүрээгүй байгаа боловч хурдац нь аюултай нэмэгдэж байна. 1985 онд цэргийн зорилгоор зарцуулж байгаа дэлхийн нийт хөрөнгөний гуравны хоёроос илүү хувь буюу 560 миллиард доллар нь Ази-Номхон далайн бүс нутагт ноогдож байгааг Лондоны стратеги судлалын институт тооцоолон гаргажээ.

Ази-Номхон далайн бүс нутаг энд байгаа цөмийн зэвсгийн тоо чанараар Өрнөд Европоос хоцорч байгаа боловч төрөл бүрийн ердийн зэвсгийн тоо, зэвсэгт хүчний хэмжээгээр бусад районуудаас хол давж байна. Ази-Номхон далайн районы 17 сая хүнтэй зэвсэгт хүчин нь дэлхийн бүх цэргийн албан хаагчдын дөрөвний гурав орчим хувийг эзэлж байгаа жишээтэй юм.

Номхон далайн бодлогынхоо түрэмгий чиглэлийг Вашингтон нуух ч үгүй байгаа юм. АНУ-ын Номхон далайн доктрины зорилго бол «ЗСБНХУ-ын эсрэг дайн» гэж Пентагонтой холбоотой, РЭНД хэмээх нөлөө бүхий корпорацийн зүтгэлтэн агсан, одоо төрийн нарийн бичгийн дарга нарын газрын хариуцлагатай ажилтан Р. Соломон 1986 оны зун мэдэгдсэн бөгөөд түүний үгээр бол «ЗСБНХУ-ын эсрэг дайн Европт эхлээд дараа нь Алс Дорнодын хоёрдугаар фронтоор нэмэгдэх» ажээ. Азийн орнуудаар аялахынхаа өмнөхөн К.Уайнбергер Аляскт 1986 оны 10-р сарын 4-нд хэлсэн үгэндээ «Зөвлөлтийн занал» гэгчээр сүр далайлгаж АНУ-ыг «дайнд бүрэн бэлэн байх» зайлшгүй шаардлагатайг тайлбарлаад «Америкийн улс төр, эдийн засгийн хүчин чадал, АНУ ын зэвсэгт хүчин, тэдгээр хүчнүүдийг өөрийгөө хамгаалахад ашиглах талаар Америкийн тууштай бодлогыг Зөвлөлтийн удирдагчдад сэргүүлэн тавихыг» уриалсан байна.

Пентагоны стратеги түрэмгий төлөвлөгөөгөө биелүүлэхэд социалист орнуудын хооронд маргаан үүсгэх, Зөвлөлт-Хятадын харилцааг эрүүлжүүлэх замд янз бүрийн саад учруулах зэрэгт илэрхий найдлага тавьж

байна. Пентагоны нэгэн дээгүүр тушаалтай төлөөлөгч саяхан мэдэгдэх дээ: «Хэрэв мэт Хятад, Зөвлөлт хоёр улс дайны эсрэг зогсвол Номхон далайн талаарх АНУ-ын стратегийг хэрэгжүүлэх явдал асар хүндрэнэ» гэжээ. Иймд дээр дурдсан үгэндээ К.Уайнбергер ЗСБНХУ, БНХАУ-ын гадаад улс төрийн бодлогын чиг шугамыг сэргэлдүүлж, мушгин гуйвуулахыг оролдсон нь гайхалтай бишээ.

Өөрийнхөө цэрэг зэвсгийн хүчин чадлыг эрс нэмэгдүүлэхийн зэрэгцээ Япон, Өмнөд Солонгосын цэргийн хүчийг идэвхжүүлэхийг АНУ чухалд үзэж Вашингтон-Токио-Сөүлийн түрэмгий тэнхлэгийг эмхлэн байгуулахыг зорьж байна. Ази-Номхон далайн бүс нутагт АНУ, Япон, Өмнөд Солонгосын цэрэг дайны бэлтгэл хэрхэн нэмэгдэж буйг энэ бүс нутагт байрласан АНУ-ын цэргийн гурав ба долдугаар флотын хүчний өсөлт, сүүлийн арван жилд Япон, Өмнөд Солонгосын цэргийн цэвэр зардал ихээхэн нэмэгдсэнээр мэдэж болно. 1975 онд АНУ-ын цэрэг тэнгисийн хүчний гурав ба долдугаар флот нисэх онгоц тээгч ердийн хөлөг онгоц 6, байлдааны бусад хөлөг онгоц 80 орчимтой байв. 1984 онд түүний хүч нь эрс нэмэгдлээ. Нисэх онгоц тээгч ердийн хөлөг онгоц 7-той болж түүн дээрээ нисэх онгоц тээгч атомын хөлөг онгоц 3, усан доогуур явагч хөлөг онгоц 50, түүнээс 40 гаруй нь атомын хөлөг онгоц, нисдэг тэрэг зөөгч 9, газар уснаа явагч хөлөг онгоц 30, дэмжигч-хөлөг онгоц 40 шахамгай болж байлдааны бусад хөлөг онгоцны тоо мөн нэмэгджээ. 1975 онд дивиз, онгоц нисгэх ганц тавцангаас бүрдэж байсан Ази-Номхон далайн бүс нутаг дахь АНУ-ын далайн явган цэргийн анги 1984 онд хэд хэдэн бригад, нисэх хүчний ба десантын газар уснаа явагч хөлөг онгоцтой дэргийн томоохон анги нэгтгэлүүдээр хүч нэмэгдүүлсэн байв. Үүнээс гадна Диего-Гарсиа-д толгойн бааз нь орших Энэтхэгийн далайд байрладаг АНУ-ын долдугаар флотын хэсгийг 70-аад оны сүүлч 80-аад оны эхнээс тасралтгүй өргөтгөж байна.

1975 онд 1327,3 миллиард иентэй тэнцэж байсан Японы цэргийн шууд зардал 1983 онд, хоёр дахинаас илүүгээр нэмэгдэж жил дутам 6,5-6.9 хувиар өсч 1986 онд 3343,5 миллиард тенд хүрчээ. Өмнөд Солонгосын цэргийн зардал 1975 — 1983 оны хооронд 5 дахин нэмэгдэж 1975 онд 0,9 миллиард ам, доллар байсан бол 1983 онд 4,4 миллиард доллар болжээ.

Вашингтон ба түүний хамсаатны улам нэмэгдэж байгаа цэрэг дайны бэлтгэлийг зөвхөн ЗСБНХУ болон социалист бусад орнуудын эсрэг дайсагнасан чиглэлийн улмаас гэж үзвэл нь буруу болохыг Америкийн цэргийн бааз, объектуудын газар зүйн өргөтгөл, цэрэг далайн хүчний тархалт гэрчилж байна. Ази, Номхон далайн районд хуримтлагдсан америкийн цэргийн хөлөг онгоц, нисэх онгоц болон түргэн хөдлөх хүчийг дуртай цагтаа бусад ямарч орны эсрэг эргүүлж болно. Учир нь энэ бүс нутгийн биеэ даасан байр суурьтай аль ч улс АНУ-ын амин чухал эрх ашиг, түүний улс дундын монополи-д учруулж буй «занал» гэж үзэж байна.

Империалистууд хүнийхээ зэрэгцээ Ази-Номхон далайн бүс нутагт харилцан үл итгэл, уур амьсгал буй болгож колоничлолын дэглэмээс өвлөгдөн үлдсэн газар нутаг, хил хязгаарын будлиан, сэргэлдөөнийг элдвээр өдөөн хатгаж, түгшүүрт байдлын голомтыг дэмжин дэвэргэж байна. Тэд Афганистан, Капучийг тойрсон сэргэлдөөнт байдлыг хомхой зорилгодоо ашиглан тэдгээр орны ард түмний эсрэг зарлаагүй дайн явуулж байна.

Ийм нөхцөлд Ази-Номхон далайн бүс нутагт учирт буй аюул заналыг зайлуулж амар түвшин тогтвортой байхын шигжим оруулах талаар

гаргаж буй ЗХУ-ын хүчин чармайлт нь биеэ даасан шинэ залуу улсуудын үндэсний тусгаар тогтнол, бүрэн эрхийг бэхжүүлэхэд хийгээд бүс нутгийн нийгэм эдийн засгийн дэвшилд үлэмж түлхэц өгөх учир холбогдолтой. Тийм замаар амжилтанд хүрэх бололцоо ч дүүрэн байна. Ази--Номхон далайн бүс нутагт улс төр-эдийн засгийн шинэ төв буй болгосны дүнд «Номхон далайн эрин» эхлэх боломжтойн талаар улс төрийн зүтгэлтнүүд, эрдэмтэд олонтой ярих болов. ХБНГУ-ын канцлер Г.Колийн бодлоор бол Ази болоод түүний хавьцаах Номхон далайн район нь ойрын 10 жилд дэлхий дахины улс төр, эдийн засгийн төв болох ажээ».

Ази-Номхон далайн бүс нутаг одоо ч гэсэн хөрөнгөт ертөнцийн үйлдвэрийн үйлдвэрлэлийн 60 орчим хувийг өгч байна. АНУ гадаад худалдааныхаа гуравны нэг хувийг энэ бүс нутгийн орнуудтай хийж байгаа ба Японы импортын 58 хувь, экспортын 55 хувь нь түүнд ноогдож байна. БНХАУ-ын эдийн засгийн гадаад харилцаанд Ази-Номхон далайн бүс нутаг бүр ч их үүрэгтэйг Хятад импортынхоо 70 хувь, экспортынхоо 60 хувийг уг бүс нутгийн орнуудтай хийж байгаагаас харж болно.

Ази-Номхон далайн бүс нутагт явагдаж буй үйл явцыг шинжлэж үзвэл тэнд үйлдвэрийн хөгжлийн шинэ чухал голомт үүсч, түүнийг империализм улс хоорондын пүүснүүдийн баяжих нөөц, эх булгаа гэж үзэж байгааг гэрчилж байна. Үүний зэрэгцээ уг район нь АНУ, Япон, Өрнөд Европын монополийн өрсөлдөх хурц тэмцлийн талбар болж хувирах нь нүдний өмнө улам бүр нэмэгдсээр байна.

Эдгээрээс гадна Ази-Номхон далайн бүс нутаг бүхэлдээ улс төр, цэрэг, үндэсний хурц зөрчлийн зангилаа газар болж байна. Энд олон улсын уур амьсгал болон хүн төрөлхтний ирээдүйд асар их нөлөө үзүүлэхүйц улс төрийн том том өөрчлөлтүүд гарч байна.

Ийм өөрчлөлтийн эх суурийг Аугаа их Октябрийн социалист хувьсгал тавьсан юм. Түүний нөлөөгөөр Дорнод ахины олон орнуудад үндэсний чөлөөлөх хөдөлгөөн өрнөсөн нь тэнд дэлхийн II дайны дараагаар империализмын колоничлолын системийг бүрэн задран унахад хүргэлээ.

«XX зуунд нойрноос сэргэж шинэ амьдралд шилжсэн Ази тив эрх чөлөө тусгаар тогтнолын төлөө тэмцлийн олон хэлбэр, арга туршлагаараа дэлхий дахины дэвшил хөгжлийг баяжуулсан» гэж Владивостоке М. С. Горбачев цохон тэмдэглэсэн билээ. Тэрээр өнөө үед Ази-Номхон далайн бүс нутагт явагдаж байгаа сэргэлтийн чанартай, нарийн төвөгтэй үйл явцыг тал бүрээс нь гүнзгийрүүлэн судлахын онол практикийн ач холбогдлыг чухалчлан заалаа. («Правда» 1986. 7. 29)

II

ЗСБНХУ-ын социалист байгуулалтын тааламжтай гадаад нөхцлийг хангах зорилт бат тууштай энх тайвныг хийгээд бүх оронтой хамтын ажиллагаагаа бэхжүүлэн хөгжүүлэхийг ирмүүн шаардаж байна. Манай энх тайванч бодлого бол цаг зуурын бодлого биш, хоосон ерөөл айлтгал ч биш, харин үндэсний гүн гүнзгий ашиг сонирхлоос үүдэн гарч буй урт хугацааны зарчимч шугам юм.

Ази-Номхон далайн бүс нутгийг олон улсын түгшүүртэй байдлын эх сурвалж болгохгүй байлгах, түүнийг бүх орон, ард түмний тусыг тулд энх тайван, аюулгүй байдал, итгэлцэл, харилцан ойлголт, тал бүрийн харилцан ашигтай хамтын ажиллагааны найдвартай бүс болгож Номхон далайг К. Марксын хэлснээр дэлхий дахины харилцааны агуу их усан замын үүрэг» гүйцэтгүүлэхийг ЗХУ чин үнэнчээр эрмэлзэж байна.

Ази-Номхон далайн бүс нутгийн асуудлаарх ЗХУ-ын хандлага юугаараа ялгаатай вэ? Юуны өмнө улс төр, эдийн засаг, цэрэг-стратег, улс үндэстэн, шашины болон бас бусад зөрчлийн нарийн төвөгтэй зангилгааг төрүүлж буй бэрхшээлийн талаарх тод томруун ойлголт, бодит реализм болно. Үүний хамт, зөвлөлтийн хандлагын реализм нь ажил хэрэгч өөдрөг үзэл, тухайлан бүс нутгийн байдал хэдийгээр ээдрээтэй бөгөөд зөрчилтэй боловч хэрэв сонирхогч бүх талууд санаа зоригоо нэгтгэвэл оршин буй асуудал, маргаан, мөргөлдөөнт байдлаар харилцан зөвших шийдвэр гаргаж болно гэдэгт эргэлзэхгүй байгаатай салшгүй хосолдог юм.

Цаашилбал, олон янзын асуудлыг зохицуулахад хандах хандлагын шинэ шинэлэг зүйл, эр зориг, бүтээлч, ажил хэрэгч чанар, итгэлцэлийн уур амьсгал буй болгох найдлага бүхий тодорхой арга хэмжээ, баталгааны боловсруулалт, бусад улсын санал санаачлагад анхааралтай хандах явдал, харилцан хүлээж болохуйц шийдвэр сүвэгчлэхэд бэлэн байх чанар, эдгээр нь Зөвлөлтийн байр суурийг ялгаатай болгож байна. Энэ нь нэг үгээр хэлбэл улс төрийн шинэ сэтгэлгээний биелэлт мөн. Ази Номхон далайн бүсийн энх тайван аюулгүй байдал хамтын ажиллагааг хангах Зөвлөлтийн программын цар хүрээг үндсэн хоёр том хэсэгт хувааж болно.

Нэгд—**бүс нутгийн улсууд хоорондоо харилцах ерөнхий зарчим, учран буй зөрчил тэмцлээ зохицуулах хандлага.** Үүнийг боловсруулахад сүүлийн жилүүдэд Азийн янз бүрийн орнуудаас дэвшүүлэн тавьсан ажил хэрэгч санал санаачлагыг харгалзсан. Үүнд «Панча Шила»-гийн зарчим, Бандунгийн 10 зарчим, уг бүс нутгийн социалист улсуудын туршлага, энх тайванч санал санаачлагууд орно. Үүнд хамаарагдах орнууд гэвэл БНМАУ, БНАСАУ, БНСВУ, БНАЛАУ, БНКАУ мөн Хятад, хөрөнгөтөн орнуудаас-Энэтхэг, Япон, АСЕАН-ы гишүүн орнууд бөгөөд тэдгээрийн дэвшүүлсэн санал санаачлагад НҮБ-ийн тогтоол, шийдвэрт заагдсан Азийн холбогдолтой зөвлөмж тусгалаа олсон байна.

Хоёрдугаар хэсэг нь бүс нутгийн улс төрийн уур амьсгалыг яваандаа алхам алхмаар эрүүлжүүлэх, зүйл бүрийн хамтын ажиллагааны хөгжилт, итгэлцэлийг бэхжүүлэх тал руу шийдэмгий эргэлт хийх боломж олгохуйц бүс нутаг, бүс хоорондын болон хоёр талын түвшинд хамаарах төрөл бүрийн арга хэмжээ, практик алхамуудын цогцолбороос бүрдэнэ. Өнөө үеийн нарийн төвөгтэй, харилцан нөлөөлөлттэй хорвоод Ази-Номхон далайн бүс нутгийн асуудлыг нийт олон улсын байдлаас салангад авч үзэх аргагүй юм. Зэвсэг хураах, цөмийн зэвсгийн сүйрэлийг сэрэмжлэн зайлуулах гэх мэт амин чухал хурц асуудлуудаар дэлхийн тайзнаа явагдаж буй тэмцлийн явц Ази-Номхон далайн бүс нутгийн төлөв байдалд мэдээж асар их нөлөөлж байна. Нөгөөтэйгүүр тэнд явагдаж байгаа үйл явдлууд олон улсын улс төрийн уур амьсгалд бүхэлд нь заримдаа маш ноцтой нөлөөлж байна.

ЗХУ тодорхой чухам ямар санал дэвшүүлж байна вэ?

Юуны өмнө улс төр, цэрэг, эдийн засгийн хүрээнд авч явуулах өргөн далайцтай тодорхой арга хэмжээнүүдийг бүх бүс нутаг даяар хэрэгжүүлэх явдал юм.

Улс төрийн салбарт ажил хэрэгч бүтээлч шийдвэр хамтран сүвэгчлэх зорилгоор аажимдаа нийт Азийн чуулга уулзалтыг сайтар бэлтгэл тэйгээр зарлан хуралдуулах явдал нааштай үүрэг гүйцэтгэж болох юм. Энэ санаачлагыг эсэргүүцэгчид, юуны өмнө улс орныг зааглан талцуулж буй маргаантай асуудлыг урьдчилан таслах хэрэгтэй гэж баталж

байна. «Тэгэхгүйгээр уулзалт маань үр ашиггүйгээр барахгүй хортой болно» гэнэ. Ийм үзэл санааг зөвшөөрөхөд хэцүү юм.

Нэгдүгээрт, Зөвлөлт санал болгохдоо нийт Азийн чуулга уулзалтыг яаран даруй түргэн явуулая гээгүй, харин Хельсинкийн туршлагыг механикаар хуулбарлалгүй, бүс нутгийн байдлын онцлогийг харгалзан бэлтгэлийг нь шатчилан сайтар хангах тухай санал дэвшүүлж байна.

Хоёрдугаарт, бүс нутаг, салбар бүс болон хоёр талын асуудлуудыг шийдвэрлэх өргөн цогцолбор арга хэмжээг чуулга уулзалтын бэлтгэлтэй хамтруулан авч явуулах нь зүйтэй гэж үзэж байна. Тийм арга хэмжээнд Кампучаас эхлээд Афганистан хүртэл, Номхон далайн өмнөд хэсгийн орнуудын цөмийн зэвсэггүй статусыг хүндэтгэхээс эхлээд Солонгосын хойг ба Зүүн-Өмнөд Азийн районыг цөмийн зэвсэггүй бүс болгон зарлах хүртэл, ЗСБНХУ-ын хоёр талын харилцааг Хятад, Японтой сайжруулахаас авахуулаад АНУ-тай хэлцээ хийх хүртэл асуудлууд багтана.

Бандунг болон Хельсинк зэрэг ижил төстэй бага хурлуудын туршлагаас үзэхэд нийт Азийн дээд хэмжээний зөвлөлгөөний бэлтгэлийг хангахад бүсийн янз бүрийн хэмжээний уулзалт буюу сонирхогч улсуудын төлөөлөгчдийн ажлын зөвлөлгөөнүүд зохион явуулж болохыг үгүйсгэхгүй юм. Гагцхүү **Азийн үйл явцыг** зөв үнэлэн энэ талаар хамтран ажиллахад бэлэн гэдгээ харуулах нь маш чухал юм.

Цэргийн талаар, хэрэгжилт нь улс тус бүрийн түгшүүртэй байдлыг мэдэгдэхүйц зөөлрүүлж аюулгүй байх итгэл найдварыг нь дээшлүүлхүйц тийм цогцолбор арга хэмжээнүүдийг ЗХУ дэвшүүлэн тавьж байна. Юуны өмнө бүс болоод салбар бүсийн хэмжээнд, түүнчлэн олон талын буюу хоёр талын үндсэн дээр итгэлцэлийн арга хэмжээг боловсруулан хэрэгжүүлэх асуудал чухал юм. Энэ талаар Стокгольмийн саяхны зөвлөлгөөний нааштай туршлагыг авч итгэлцлийн хэлэлцээрийн арга хэмжээнд цэргийн томоохон шилжин байрлалт, хуурай замын хүчний томоохон сургуулилалт, түүндээ ажиглагч ирүүлэх, цэргийн төлөөлөгчид солилцох зэрэг бүс нутгийн цэрэг улс төрийн байдлын онцлогийг харгалзан явуулж болох бусад хэлбэрийн арга хэмжээнүүдийн талаар урьдаас харилцан мэдээлцгээж болох юм. Энэ бүхэн нь ЗХУ болон Азийн бусад социалист орнуудын хилийн яг дэргэд АНУ ба түүний холбоотнуудын явуулж байгаа хээрийн сургуулийн тоо хэмжээ жил бүр нэмэгдэж байгаатай холбогдон бүр ч чухал юм. Өмнөд Солонгосын нутаг дээр явагдан «Тим спирит — 86» хээрийн сургуульд гэхэд л Америк ба Өмнөд Солонгосын 200 мянга гаруй цэрэг дарга оролцжээ. Японы «өөрийгөө хамгаалах хүч» зөвхөн 1985 онд дэвсгэр нутаг дээрээ АНУ-ын зэвсэгт хүчинтэй хамтарсан хээрийн сургуулийг 20 удаа хийсэн байна. Тэдний заримыг ЗХУ-ын хилд ойрхон Хоккайдо арал дээр явуулсан юм.

Дэлхийн II дайнаас хойш хамгийн том цэрэг-тэнгисийн хээрийн сургууль Ази-Номхон далайн сав газарт л явагдлаа. Жишээ нь «Римпак— 86» хээрийн сургуульд «Карл Винсон», «Рейнджер» гэх мэт цохилтын нисэх онгоц тээгч цэргийн 50 хөлөг онгоц, АНУ, Япон, Англи, Канад, Австралийн 250 нисэх онгоц, 50 мянга орчим цэрэг, дарга нар оролцжээ. 1986 оны 9-р сард Америкийн 7-р флотын хөлөг онгоцнууд Япон далай Агнуурын далай хоёрын уулзвар дээр буюу өөрөөр хэлбэл Зөвлөлтийн Алс Дорнодын хилийн яг дэргэд хээрийн сургууль хийлээ. Ийм учраас хээрийн сургууль шууд өдөөн хатгах шинж чанартай боллоо гэж Японы хэвлэл шууд илчилж байлаа. Цөмийн нэг авч болох чадалтай «Тома гавк» хэмээх далавчит пуужингаар тоноглогдсон «Нью-Джерси» лонкор тэргүүтэй Америкийн 7-р флотын хөлөг онгоцны цохилтын хэсэг уг хээрийн сургуульд оролцжээ.

Ази-Номхон далайн бүс нутагт хүч үл хэрэглэх болон Алс Дорнодод итгэлцэл буй болгох явдлыг тулж ярилцах цаг нэгэнт боллоо. Тийм зорилтыг шийдвэрлэх алхам Номхон далайн усан замын тээврийн аюулгүй байдлыг хангах, олон улсын терроризмыг цаазлан хориглох гэх мэт энгийн боловч наадхан захын гарцаагүй асуудлыг авч хэлэлцэхээс эхэлж болох юм гэж ЗХУ үзэж байна.

Ази-Номхон далайн бүс нутгийн аюулгүй байдал, хамтын ажиллагааны талаарх Зөвлөлтийн энх тайванч программ нь үл гүйцэлдэх зүйл биш харин уг бүс нутагт багтах бүх орны эрх ашиг, бололцоо нөхцлийг харгалзсан үнэн бодит, цэгнэж дүгнэсэн, тодорхой санал санаачилгуудын цогцолбор болно.

Түгшүүртэй байдлыг намжаах цэрэг, улс төрийн арга хэмжээнүүд, бүсийн орнуудын хооронд харилцан ойлголцох, хамтран ажиллах явдлыг гүнзгийрүүлэх эдийн засгийн найдвартай материаллаг үндсийг бүтээж чадахуйц **эдийн засгийн** төрөл бүрийн арга хэмжээ гарцаагүй шаардлагатай гэж ЗХУ үзэж байна. Зарчмын ийм байр сууринаас хандахдаа ЗХУ-ын засгийн газар тэгш эрхтэй, харилцан ашигтай, худалдаа, эдийн засаг технологи, соёл, шинжлэх ухааны хамтын ажиллагаа тогтоох алхам хийхийг дэлхийн энэ хэсгийн бүх улсуудад уриалсан юм. Эдийн засгийн хамтын ажиллагааны хүрээнд үйлдвэрлэх хүчнийг хөгжүүлэх, далай тэнгисийн нөөцийг эзэмших боловсон хүчин бэлтгэх, эрчим хүч, түүний дотор цөмийн эрчим хүчний шинэ шинэ эх булгуудыг ашиглах, тээвэр холбооны хэрэгслэлүүдийг боловсронгуй болгох зэрэг асуудлыг багтааж болно.

Ази-Номхон далайн районд цэрэг-эдийн засгийн явцуу бүлэглэл байгуулахын эсрэг тэмцэж, харин бүх орнуудын хооронд харилцан ашигтай хамтын ажиллагаа тогтоон хөгжүүлэх үүднээс «Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагаа»-ны үзэл санаанд ч ЗХУ нааштай хандаж, түүнд оролцох бололцоо тодорхой хэлбэрийг авч үзэхэд бэлэн байна. Үүний хамт хөгжиж байгаа орнуудын дэвшүүлсэн олон улсын эдийн засгийн шинэ дэглэм тогтоох үзэл санааг манай орон идэвхтэй дэмжинэ.

Энх тайвнаар зэрэгцэн орших ба сайн хөршийн зарчмыг хатуу мөрдөх замаар бүс нутгийн орнуудын хоорондох **хоёр талын харилцааг** хөгжүүлбэл Ази тивд энх тайван, аюулгүй байдлын бат бэх системийг аажмаар тогтоох үйлсэд доривтой хувь нэмэр болох учиртай билээ. Энэ талаар ч гэсэн ЗХУ Азийн орнуудтай харилцаагаа хөгжүүлэх асуудал, шинэ хандлага гаргаж хэд хэдэн маш ирээдүйтэй чухал санал дэвшүүлэн тавьж, ам ажлын нэгдлийг дахин харууллаа. Энэ бүс нутгийн бүх улсуудтай цөмтэй нь харилцаагаа өргөтгөхийг ЗСБНХУ эрмэлзэж байна. Монгол, БНАСАУ, Вьетнам, Лаос болон Кампучитай эв санааны нэгдэл, тэгш эрхийн зарчим дээр үндсэлсэн хамгийн дотно найрамдалт харилцаагаа хөгжүүлэх явдал манай улс төрийн бодлогод чухал байр эзэлдэг юм. Эрх чөлөө, тусгаар тогтнолынхоо төлөө тэмцлийн хүнд хүчир замыг туулж өнгөрсөн эдгээр орнууд энх тайван, энх тайвнаар хамтран ажиллах зарчим, тусгаар тогтнолыг онцгой үнэлдэг юм. Эдгээр орнууд тус бүрдээ олон улсын тавцан дээр өөр өөрийн онцлог нүүр царайтай бөгөөд Азийн байдлыг үндсээр нь эрүүлжүүлэхэд чиглэгдсэн том хэмжээний санаачлагууд дэвшүүлж тавьдаг юм.

Ази, Номхон далайн улсуудын хоорондох харилцаанд харилцан үл довтолох, хүч үл хэрэглэх тухай конвенц байгуулах явдал бүс нутгийн онц тайван, аюулгүй байдлыг хангахад чухал ач холбогдолтой болохсон билээ. БНМАУ-ын засгийн газрын 1981 онд дэвшүүлсэн энэ санал уг бүс нутгийн түгшүүртэй байдлын түвшинг эрс бууруулах боломж олгож

улмаар олон улсын уур амьсгалыг эрүүлжүүлэх урьдчилсан нөхцлийг бүрэлдүүлэхсэн. Саналыг Азийн олон тооны том орнууд, түүний дотор ЗСБНХУ, БНСВУ, Энэтхэг дэмжсэн юм.

Ази, Алс Дорнодын аюулгүй байдлын систем тогтооход нэг салшгүй бүрэлдэхүүн хэсэг нь Солонгосын хойгийн байдлыг хэвийн болгож түгшүүртэй байдлыг зөөлрүүлэх, Солонгосын асуудлыг аль болох түргэн шийдвэрлэх явдал мөн. Өмнөд Солонгосоос АНУ-ын цэрэг, цөмийн зэвсгийг гаргахад чиглэгдсэн БНАСАУ-ын чармайлт, Хойгийг цөмийн зэвсэггүй, энх тайвны бүс болгож хувиргах, хөндлөнгийн оролцоогүйгээр улс орноо энх тайван, ардчилсан замаар нэгтгэх тухай асуудлуудыг ЗХУ бүрэн дүүрэн дэмжиж байна.

Цөмийн зэвсгийг дэлгэрүүлэхгүй байх тухай гэрээнд БНАСАУ саяхан нэгдэн орж цөмийн зэвсэг турших, үйлдвэрлэх ачиж оруулах, дэвсгэр нутаг дээрээ цөмийн зэвсэг байрлуулахаас дангаараа татгалзах, түүнийг нутаг дэвсгэр, агаарын ба усан замаараа дамжуулахыг хориглох болсон нь өргөн цуурайтаж байна. Эдгээр асуудлаар АНУ, Өмнөд Солонгостой хэлэлцээ эхлэхэд БНАСАУ бэлэн байгаа юм. БНАСАУ-ын саналыг хэрэгжүүлж чадвал Солонгосын хойг дахь цөмийн мөргөлдөөний эгзэгтэй голомтыг дарахад чухал үүрэг биелүүлж энэ районд бат бэх энх тайвныг хангахад доривтой алхам болохсон билээ.

Азийн ард түмний энх тайван, үндэсний аюулгүй байдлын төлөөний тэмцэлд Энэтхэг-Хятадын хойгийн социалист улсууд, юуны өмнө Вьетнамын баатарлаг ард түмэн жинтэй хувь нэмэр оруулж байна. 30 гаруй жил дайнд сүйдсэн аж ахуйгаа сэргээн босгож, шинэ амьдралыг цогцлон байгуулахад нь энх тайван нөхцөл энгүй шаардагдаж буй тэдгээр ард түмэн бүх орнууд, юуны өмнө хөрш зэргэлдээ Хятад болон АСЕАН-ны гишүүн орнуудтай сайн хөршийн харилцаа тогтоохын төлөө, хүнд хүчир өнгөрсөн үеэс үлдсэн бие биенээ хардах сэжиглэх, харилцан үл итгэлцэх явдлыг аажмаар таягдан хаяхын төлөө гуйвалтгүй тэмцэж байна.

Зүүн өмнөд Азийг энх тайван, тогтвортой байдал, хамтын ажиллагааны бүс болгон тунхаглах явдлыг болон Хятад, АСЕАН-ы орнуудтай үл довтлох тухай гэрээ байгуулах саналыг ЗХУ дэмжиж байна. Тэрээр БНХАУ ба Вьетнамын хооронд нөхөр ёсны хэлцээ эхэлж хэрэгт хэрэггүй хардлага, үл итгэх явдлыг орхиод сайн хөршийн харилцаагаа сэргээн хөгжүүлэхийг хэн хэндээ ашигтай гэж үзэж байна.

Энэтхэг-Хятадын ба АСЕАН-ны орнуудын хооронд харилцан хүлээж болохуйц харилцаа тогтоовол уг салбар бүсийн энх тайвны үйлст чухал нэмэр хандив болж чадахсан. Ингэхэд давж тууламгүй бэрхшээл ер үгүй бөгөөд гагцхүү хоёр тал үнэнхүү сайн санааны үүднээс хандах нь чухал бөгөөд хөндлөнгийн оролцоог арилгууштай билээ.

Ази ба Номхон далайн сав нутагт гарсан ба гарч болох асар их өөрчлөлтийн талаар сэтгэн бодоход энэ талаар Бүгд Найрамдах Хятад Ард Улс ихээхэн үүрэгтэйг хэлэхгүй байж болохгүй.

Дэлхийн II дайнд Японы милитаристуудыг бутцохисны дараагаар Хятадын яруу алдарт хувьсгал ялсан нь энэ бүс нутгийн хөгжилд чанарын шинэ шат болж дэлхий дахины нийгэм-улс төрийн өөрчлөлтийг мэдэгдхүйц хурдатгасан юм. БНХАУ 70-аад онд АНУ, Японтой харилцаагаа хэвийн болгож, дараа нь Зөвлөлт-Хятадын харилцааг сайжруулж эхэлсэн үйл явц ч Ази-Номхон далайн бүс нутгийн стратег хүчний байдалд олон шинэ агшин оруулсан юм. Энх тайвнаар зэрэгцэн орших нийтлэг зарчмыг бататгах үүднээс авч үзэхэд ЗСБНХУ, БНХАУ, АНУ, Японыг оролцуулан Ази-Номхон далайн бүс нутгийн орнуудын

хооронд хэвийн харилцаатай байх явдал хэрэв бусад улсын аюулгүй байдалд харшлаагүй бол гарцаагүй өөдрөг үзэгдэл юм.

Хятадтай харилцах харилцаагаа чухал ач холбогдолтой гэж ЗХУ гуйвалтгүй үзэж байна. М.С.Горбачевын заасанчилан «Зөвлөлт ба Хятадын ард түмэнд туйлын хариуцлагатай үүргийг түүх ноогдуулж байна. Социалист хоёр том улсаас олон улсын харилцааны олон зүйл шалтгаална». ЗСБНХУ, БНХАУ-ын харилцаа сүүлийн үед бүхэлдээ өөдлөх шугамаар яваад Зөвлөлтийн хүмүүс хийгээд дэлхий дахины сайн санаат бүх хүмүүс сэтгэл таатай байна. Эдийн засаг, шинжлэх ухаан техник, соёлын хамтын ажиллагааны салбарт харилцаа өргөжиж чанарын шинэ түвшинд гарлаа. 1984 оны 12-р сараас эхлэн ЗСБНХУ, БНХАУ -ын засгийн газрын тэргүүний орлогч нар байнга харилцан айлчилж байна. Хоёр талын болон олон улсын харилцааны чухал асуудлаар гадаад яамдын сайд нарын хэмжээний зөвлөлдөөн тогтмол явагдаж байна. Хууль тогтоох дээд байгууллагын төлөөлөгчдийг 20 гаруй жил тасалдсаны дараа дахин солилцож эхэлсэн нь улс хоорондын харилцааг хэвийн болгоход чухал ач холбогдолтой томоохон үйл явдал боллоо.

Олон улсын чанартай гол гол асуудлаар санал нийлэх хандлагын хүрээ хоёр орны хооронд аажмаар өргөжиж байна. Цөмийн зэвсгийг түрүүлж хэрэглэхгүйн талаар дангаар үүрэг авсан цөмийн хоёр том гүрэн бол ЗСБНХУ, БНХАУ хоёр болно. Цөмийн туршилтаа азнах талаар ЗХУ мэдэгдсэний дараахан БНХАУ агаар мандалд цөмийн туршилт хийхээ түтгэлзэх тухай зарласан юм. Хятад газар доорхи цөмийн дэлбэлэлт хийлгүй хоёрдох жилээ болж байна.

Дайн, энхийн асуудлаарх хандлагад ижил төстэй зүйл манай орнуудад олон байна. Зэвсэглэлээр хөөцөлдөх явдлыг сансрын уудамд дэлгэрүүлэхгүй байх хийгээд Ойрхи Дорнод, Африкийн өмнөд хэсэг, Төв Америкийн зэрэг чухал асуудлаар тус хоёр орны байр суурь үндсэндээ нийцэж байна. ЗСБНХУ, БНХАУ-ын харилцааг хэвийн болгох үйл явц гуравдах орныг хохироохгүй, тэдний эрх ашигт харшлахгүй гэдгийг урьд нь нэг биш удаа тэмдэглэж байсан бөгөөд одоо ч онцлон тэмдэглэх нь зүйтэй юм.

Энх тайванч биеэ даасан тусгаар бодлого явуулж буй том гүрэн БНХАУ-ын үүргийг ЗСБНХУ харгалзан түүний хууль ёсны эрх ашгийг хүндэтгэж, байр суурийг нь, тухайлбал, Тайваны тухай асуудлаар Хятадын салшгүй хэсэг гэж дэмждэг юм. Ижил төстэй нийгэм-эдийн засгийн байгууламж, газар зүйн хөрш зэргэлдээ байрламж, нийгэм-эдийн засгийн хөгжилтийг түргэтгэх талаар шийдвэрлэж байгаа нэг ижил зорилтууд, бие биеэ нөхсөн эдийн засгийн хамтын ажиллагаа энэ бүхэн Зөвлөлт-Хятадын харилцааг харилцан ашигтай байх, бүрэн эрх, сайн хөршийн зарчмыг хатуу сахих үндсэн дээр цаашид хөгжүүлэхэд тус дөхөм үзүүлэх нь зайлшгүй.

Үүний зэрэгцээ манай орнуудын хооронд оршин буй санал зөрөөтэй асуудал, ялгаатай хандлагыг бид харахгүй байж болохгүй бөгөөд харин түүнийг даван туулах арга замыг эрж сурвалжлахыг эрмэлзэж байна. «Сайн хөршийн байдлыг бий болгох нэмэгдэл арга хэмжээний талаар Хятадтай хэзээ ямар цагт ч гэсэн, ямар түвшинд ч атугай буурь суурьтай шүүн хэлэлцэхэд Зөвлөлт Холбоот Улс бэлэн байна» гэж нөхөр М. С. Горбачев цохон тэмдэглэсэн билээ.

Ази дахь зэвсэгт хүчин болоод ердийн зэвсэглэлийг хангалттай ухаалаг хэмжээнд хүртэл эрс хорогдуулах явдлыг ЗХУ чухалд үзэх учраас хуурай замын зэвсэгт хүчээ харилцан ижил хэмжээгээр багасгахад чиглэсэн тодорхой алхмуудыг Хятадтай авч хэлэлцэх санал дэвшүүлж чухал санаачлага гаргасан юм.

Тооны хувьд хамгийн их зэвсэгт хүчин бүхий хоёр том гүрний хооронд тийнхүү хэлэлцэн тохиролцох явдал бүс нутаг, дэлхий дахины хурцадмал байдлыг намжаахад даацтай хувь нэмэр болохоор зогсохгүй бусад оронд сайхан жишээ үзүүлж Энэтхэг ба Энэтхэг-Хятадын хойгийн орнуудтай Хятадын харилцааг зөөлрүүлэхэд тус дэмжлэг үзүүлэхсэн билээ.

Бүр ойрын ирээдүйд хэрэгжүүлж болох хамтын ажиллагааны тодорхой арга хэмжээ болгож усны аж ахуй болон эрчим хүчний объектын барилгыг оролцуулан Амар мөрний нөөц баялагийг хамтын хүчээр эзэмшин ашиглах болзолгоор хэлэлцээр хийх саналыг бид дэвшүүлж тавилаа. Түүнчлэн Хятадын ард түмэнтэй сайн хөршийн харилцааны үүднээс хил орчмын гол мөрний шугам тогтоох асуудлаар ЗХУ шинэ санал дэвшүүлж байна.

Итгэлцэлийн уур амьсгал буй болгох, ерөнхий төлөв байдлыг эрүүлжүүлэх үйлсэд хувь нэмэр оруулах зорилгоор ЗХУ-ын засгийн газар БНМАУ, БНААФУ-ын засгийн газруудтай зохих ёсоор зөвлөлдсөний дараа 11-р сарын дундуур (1986 оны) гэхэд Афганистанд түр байрлаж байгаа Зөвлөлтийн хязгаарлагдмал тоо хэмжээний цэрэг ангийн бүрэлдэхүүнээс 6 хороог буцаан татах, Монголд байгаа Зөвлөлтийн цэргийн тоог нэлээд хэмжээгээр хорогдуулах шийдвэр гаргасан билээ. ЗСБНХУ-ын эдгээр үйл ажиллагаа Хятад болон хөрш зэргэлдээ бусад орнуудад нааштай үнэлэгдэж харилцан итгэлцлийг гүнзгийрүүлэхэд дэмжлэг үзүүлнэ гэдэгт найдаж болно.

Зөвлөлт-Хятадын харилцааны ахицтай хөгжилт Ази-Номхон далайн бүс нутгийн олон улсын уур амьсгалыг эрүүлжүүлэхэд чухал агшин болно гэж итгэх бүрэн иш үндэстэй юм.

Номхон далайн их гүрнүүдийн нэг бол **Америкийн Нэгдсэн Улс** билээ. Ази-Номхон далайн сав газрын олон улс-улс төрийн байдал хэлбэржин тогтоход ЗСБНХУ-ын роль үүрэг, ач холбогдлыг үгүйсгэхийг хичээгч АНУ-ын харгис хүчний хандлагаас эрс ялгаатайгаар ЗХУ энэ бүс нутагт АНУ-ын хууль ёсны эрх ашгийг хүлээн зөвшөөрөх төдийгүй түүнийг өөрийнхөө үйл ажиллагаанд харгалзан үзэж байна. Номхон далайн бүс нутгийн аюулгүй байдлын хамтын ажиллагааны асуудлыг АНУ-ын оролцоогүйгээр шийдвэрлэх боломжгүй юм гэдгийг ЗСБНХУ иш үндэс болгож байна. Хоёр тал байр сууриа уялдан зохицуулах, хоорондынхоо харилцааны бүхий л хүрээнд харилцан хүлээж болохуйц тохиролцсон хэлэлцээр боловсруулах арга замыг хайж олох ёстой.

Зөвлөлтийн Алс Дорнод (ялангуяа түүнийг эрчимтэй хөгжүүлэх төлөвлөгөөтэй уялдаж) АНУ-ын баруун эргийн районуудын хооронд худалдаа эдийн засгийн харилцааг нэлээд хөгжүүлэх бүрэн бололцоотой юм. АНУ-аас гадна Япон, Хятадыг ч оролцуулсан хамтарсан үйлдвэр байгуулах, нүүрс, нефть, хий зэргийн нөөцийг эзэмших хоёр талын болон олон талын эдийн засгийн хамтын ажиллагааны том хэмжээтэй, урт хугацааны проект боловсруулах бололцоотой юм.

Дэлхийн энэ районы энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэхэд ЗСБНХУ, Японтой сайн хөршийн харилцаа тогтоох явдал чухал ач холбогдолтой. Дэлхий дахины байдлыг эрүүлжүүлэх үйл явцад Японыг аль болох өргөнөөр татан оролцуулахыг ЗСБНХУ чухалд үзэж байна. Дэлхий дахины бодлого дахь Японы бүтээлч роль үүргийн өсөлт нь гагцхүү Ази-Номхон далайн бүс нутгийн энх тайван, аюулгүй байдал, олон талт хамтын ажиллагааны асуудлыг шийдвэрлэхэд Японы оруулах нааштай хувь нэмэртэй нягт уялдаатай явагдах ёстой.

Энэ талаар ЗСБНХУ, Японы хооронд жинхэнэ сайн хөршийн харилцаа буй болгох явдал чухал ач холбогдолтой юм. Улс төр, эдийн засаг, шинжлэх ухаан техник зэрэг салбаруудад манай орнуудын хамтран

ажиллах нөөц бололцоо үнэхээр асар их байна. Хоёр орны оюуны болоод үйлдвэрийн өндөр потенциал нь атомын эрчим хүч болон сансрыг энх тайвны үйлсэд ашиглах, дэлхийн тэнгисийн биологи ба минералын нөөцийг ашиглах ба сэргээх замыг судлах зэрэгт явуулах хамтын ажиллагааны үр ашгийг хангаж чадахсан билээ.

х х х

М. С. Горбачев Владивостокоос Ази-Номхон далайн бүх орнуудыг энх тайван, аюулгүй байдлын төлөө хамтын ажиллагаанд уриалан дуудаж: «Хэн энэ зорилгод тэмүүлнэ, Хэн ард түмнийхээ ирээдүйн сайн сайхныг эрхэмлэнэ, тэд бүхэн манайхаас сайн санаат хүмүүс, үнэнч түншээ олж чадна» гэж мэдэгдсэн билээ.

Энх тайван, аюулгүй байдлыг хангах Азийн үйл явцын талаарх зөвлөлтийн баримтлалыг НҮБ болон олон улсын бусад чуулга уулзалтууд, Ази-Номхон далайн болон бусад бүс нутгийн орнуудын удирдагчдын уулзалт, эрдэм шинжилгээний симпозиум, бага хурлууд дээр өргөн хэлэлцэж эрдмийн бүтээл, хэвлэлийн өгүүлэлд өргөн тусгаж байна.

Ази болон Номхон далайн сав газрын шийдвэл зохих цаг нь болсон хурц асуудлуудыг шийдвэрлэх эрхэм зорилгод ЗХУ-ын дэвшүүлсэн санал санаачлагууд нийцэж байна. Азийн орнууд хоорондынхоо харилцааг зохицуулах баялаг олон талт, мөн яггүй нарийн төвөгтэй туршлагыг Владивостокийн концепци анх удаа нэг ерөнхий хувиарт оруулж түүнийг Европын улс төрийн практикийн ололтоор баяжуулаад бүс нутгийн орнуудын бүх нийтийн аюулгүй байдлыг хангах тэдний харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх эрхэм дээд зорилтын үүднээс Ази Номхон далайн бүс нутагт байрладаг бүх улсуудын эрх ашгийг зохицуулах замыг эрж олоход хандуулж байна. Энэхүү концепци Азийн орнуудын улс төрийн сэтгэлгээг дайчилж: ХХ зууныг дуусахаас наана маргаантай асуудлаа зохицуулж, харилцан хүлээж авахуйц тохиролцоонд хүрэх арга зам хайж олох гол гогцоо болно.

Цөмийн сүйрэлийн аюулыг зайлуулах, Ази-Номхон далайн бүс нутаг хийгээд даян дэлхийн олон улсын уур амьсгалыг эрүүлжүүлэхэд алхам алхамаар урагшлахын төлөө нарийн төвөгтэй олон асуудлаар хийх хэлэлцээнд Зөвлөлтийн ажил хэрэгч, тодорхой санал санаачлагууд таатай үндэс суурь тавьж өгнө.

Орос эхээс товчлон орчуулсан **Э. Пунцаг**